

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

**ЗАМЫН-ҮҮД НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ
ХООЛ ХҮНС НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Тендер шалгаруулалтын нэр : ***Замын-Үүд Нэгдсэн эмнэлэгт хоол хүнсний
материал нийлүүлэх***

Гэрээний нэр, дугаар: ***ТБ-Б/06/2020***

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер зарлах өдөр: 2020.03.08

Дорноговь аймгийн Замын-Үүд Хотын захирагчийн ажлын алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Замын-Үүд Нэгдсэн эмнэлэгт хоол хүнсний материал нийлүүлэх” цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

БАГЦ-01 ГУРИЛ ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮН- 4 201 400 төгрөг

БАГЦ-02 ХҮНСНИЙ НОГОО-3 540 810 төгрөг

БАГЦ-03 БУСАД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН-7 014 690 төгрөг

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03-р сарын 17-ний өдрийн 09 цаг 00 минутад нээнэ.

Тендерийн материалыг 2020 оны 03-р сарын 17-ний өдрийн 09 цаг 30 минутаас өмнө www.tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Замын-Үүд сум Сүлд баг

Нутгийн удирдлагын ордон 2 давхар 17 тоот Утас: 70527500

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

4. **Тогтмол үнэ** 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨЭЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
--	-------------------------

<p>ТОӨЗ 1.1</p>	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх - Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлэх / гэрээ, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол/ - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Татварын газрын тодорхойлолт/өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх -Шүүхийн тодорхойлолт. Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх -Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ төсөвт өртөгийн 80%-иас дээш - Нийлүүлэх барааны үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх. - Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ, <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөл Үүнд: Гадаад худалдаа / хүчинтэй хугацаа дуусаагүй байх , хүчинтэй хугацаа дуусч эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлэх явцад байгаа зөвшөөрлийг хүчинтэйд тооцож хүлээн авахгүй /</p> <p>Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх: шаардлагагүй</p> <p>Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх шаардлагагүй</p>
-----------------	---

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендер хүлээн авах этгээд: tender.gov.mn цахим сайтаар</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд баг , Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 17 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03-р сарын 17-ний өдрийн 09 цаг 00</p> <p>Тендерийн хүлээн авах хийх газар, хугацаа нь:</p> <p>Байшин, гудамжны нэр: Монгол Улс Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Т Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд баг , Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 17 тоот</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 03-р сарын 17-ний өдрийн 09 цаг 30</p>

ТӨӨЗ 2.3

Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:

- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх

- Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлэх / гэрээ, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол/

- Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар

- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл

- Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

- Татварын газрын тодорхойлолт/өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

-Шүүхийн тодорхойлолт. Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

-Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ төсөвт өртөгийн 80%-иас дээш

- Нийлүүлэх барааны үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх.

- Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ,

- Оролцогч албан ёсны цахим хаяг болон байгууллагын хаяг, утасны дугаарыг бичиж ирүүлэх

Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөл Үүнд: **Шаарлагатай**

/ хүчинтэй хугацаа дуусаагүй байх , хүчинтэй хугацаа дуусч эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлэх явцад байгаа зөвшөөрлийг хүчинтэйд тооцож хүлээн авахгүй /

	<p>Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх: шаардлагагүй</p> <p>1. Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх шаардлагагүй</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>БАГЦ-01 ГУРИЛ ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮН- 4 201 400 төгрөг</p> <p>БАГЦ-02 ХҮНСНИЙ НОГОО-3 540 810 төгрөг</p> <p>БАГЦ-03 БУСАД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН-7 014 690 төгрөг</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАГЦ-01 ГУРИЛ ГУРИЛАН БҮТЭЭГ ДЭХҮҮН

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шинж чанар
1	Гурил	кг	750	MNS 0244-2009 стандартыг хангасан, үнслэг 0.75%-иас ихгүй, цавуулаг 30.0% - иас багагүй хзчиллэг 4.0 Н-иас ихгүй , чийглэг 15.5 %ийс ихгүй байх
2	Гурвалжин будаа	ш	188	MNS 6511;1998 чанарын шаардлага хангасан байх.
3	Арвайн гурил	ш	3	MNS 5411;2004 чанарын шаардлага хангасан байх
4	Дамбаоли	ш	3	500 гр савлагдсан байх
5	Лапша гоймон	ш	91	
6	Каша	ш	169	MNS 05254;1989 чанарын шаардлага хангасан байх
7	Цагаан будаа	кг	500	MNS ISO 7301;2000 чанарын шаардлага хангасан амьтны гаралтай хольц агуулаагүй байх.
8	Шар будаа	ш	239	MNS 0533;1998 чанарын шаардлага хангасан гадны хогт хольц 05 %-иас ихгүй

БАГЦ-02 ХҮНСНИЙ НОГОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шинж чанар
1	Байцаа	кг	545	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан өнгө үзэмж хэлбэр дүрсээ алдаагүй монголд тарьсан шинжилгээний бичигтэй байх.
2	Брокли	кг	65	MNS 2728-1;2014 MNS 2783;2005 чанарын шаардлага хангасан гадны мэдэгдэх үнэргүй хэлбэрээ алдаагүй шинжилгээний бичигтэй байх
3	Далайн байцаа	ш	107	Иодын хэмжээ 0.1 %-0.13% илчлэг 20 ккал. Нүүрс ус 0.5 % өөх тос 1%, уураг 1% иас ихгүй байх.
4	Лууван	кг	291	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан өнгө үзэмж хэлбэр дүрсээ алдаагүй монголд тарьсан шинжилгээний бичигтэй байх.
5	Манжин	кг	167	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан өнгө үзэмж хэлбэр дүрсээ алдаагүй монголд тарьсан шинжилгээний бичигтэй байх.
6	Сонгино	кг	118	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан өнгө үзэмж хэлбэр дүрсээ алдаагүй монголд тарьсан шинжилгээний бичигтэй байх.

7	Төмс	кг	982	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан өнгө үзэмж хэлбэр дүрсээ алдаагүй монголд тарьсан шинжилгээний бичигтэй байх.
8	Чинжүү	кг	31	MNS 2728-1;2014 MNS 2783;2005 чанарын шаардлага хангасан гадны мэдэгдэх үнэргүй хэлбэрээ алдаагүй шинжилгээний бичигтэй байх
9	Шөлний байцаа	ш	34	MNS 2728-1;2014 MNS 2783;2005 чанарын шаардлага хангасан гадны мэдэгдэх үнэргүй хэлбэрээ алдаагүй шинжилгээний бичигтэй байх

БАГЦ-03 БУСАД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Шинж чанар
1	Үзэм	кг	150	MNS 5132;2002 чанарын шаардлага хангасан. Шинжилгээгээр хөгц мөөгөнцөр илрээгүй байх
2	Өндөг	ш	1,782	MNS 92 – 77 чанарын шаардлага хангасан, дотоодын бүтээгдэхүүн байх
3	Варень	ш	5	
4	Давс	ш	50	Иоджуулсан монгол бор давс байх.
5	Дошида	ш	35	
6	Зөгийн бал	ш	2	Монголд үйлдвэрлэсэн байх.
7	Их тайга цай	ш	30	MNS 5131-2002 чанарын шаардлага хангасан байх
8	Монгол цай	ш	4	MNS 5131-2002 чанарын шаардлага хангасан байх
9	Ургамлын тос	ш	197	MNS 6646;2016 чанарын шаардлага хангасан байх
10	Чацаргана	кг	370	MNS 4377:96 стандартыг хангасан, хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй, шинжилгээний бичигтэй монголд тарьсан байх
11	Элсэн чихэр	кг	385	MNS CAC 212:2014 стандартыг хангасан байх
12	Масло	кг	130	82 %-ын тослогтой транс тос агуулаагүй байх

- 1. Бараа хүргэх газар:** Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг
- 2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойл олт	Тоо ширхэг	Хэмж их нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэ х хамгийн эхний хугацаа	Нийлүүлэ х эцсийн хугацаа	Нийлүүлэ гчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Үнэлгээний хорооны дарга Ц.Саруулсайхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших

1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт

2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх

3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх

4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа

5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[тоо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах

6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр

7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.

- | | |
|---|--|
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг⁴;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]